

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЦЭХ-ний боловсруулалт




График 3. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт

Компани 2022 онд 151.6 сая кВтц ЦЭХ боловсруулах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 157.8 сая ЦЭХ боловсруулж төлөвлөгөөг 4.09 сая кВтц-аар нэмэгдүүлж 102.7%-иар биелүүлсэн байна.

ЦЭХ –ний түгээлт:

Тайлант хугацаанд 132.2 сая кВтц ЦЭХ түгээх төлөвлөгөөтэй байснаас 136.6 сая кВтц ЦЭХ түгээж 103.3%-ийн биелэлттэй гарсан. 2022 онд хийгдэх байсан ТГ№3-ын их засварын ажил хойшилсоноор өсөн нэмэгдэж буй ЦЭХ-ний хэрэглээнд сар бүр оролцож ажилласан нь нийт 4.4 сая кВт ЦЭХ-ийг илүү түгээх боломж бүрдсэн.




График 4. Цахилгаан эрчим хүчний түгээлт

ДХЦЭХ:

Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хэрэгцээ жил бүр буурч байгаа хэдийч тайлант онд 12.27% гарсан ба өнгөрсөн оны гүйцэтгэлээс 0,26%-иар буюу 626,1мян.кВт -аар нэмэгдсэн. Энэ нь 1,2-р саруудад ДХЦЭХ төлөвлөсөн хэмжээнээс 1.1%-иар, өмнөх оноос 1.8%-иар хэтрэлттэй байсан нь нөлөөлж байна. Мөн 11,12-р саруудад Багануур уурхайн ажиллагаа хүндэрч дулаан гаргах чадвар багатай нүүрс ирсэн нь горим ажиллагаанд нөлөөлж найдвартай ажиллагааг хангах үүднээс эрчим хүч хэмнэлтийн горимд ажиллаагүйтэй холбоотой юм.

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ





График 5. Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч/хувиар/

Дулааны эрчим хүчний талаар

2022 онд усаар 195834 Гкал, уураар 45306 Гкал, нийт 241140 Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 19075 Гкал илүү түгээж төлөвлөгөөний биелэлт 108.6% байна. Диспетчерийн графикийн зөрчилгүй ГОТ 100 % биелсэн. Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 6236 Гкал их түгээж 102.7 %-н биелэлттэй байна. Дулааны түгээлтийн бүтцийг харуулбал: Нийт дулааны түгээлтийн 74.9 хувийг буюу 180579 Гкал-ыг УБДС ХК, коллектороос 6.3 хувь буюу 15255 Гкал, уураар 18,8 хувь буюу 45306 Гкал тус тус түгээсэн байна.



Дулааны эрчим хүчний түгээлтийн биелэлтийг сар бүрээр графикаар харуулбал:




График 7. Дулааны эрчим хүчний түгээлт

2022 онд уураар 45306 Гкал дулаан түгээсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 13956 Гкал-аар нэмэгдсэн, өмнөх онтой харьцуулахад 916 Гкал-аар өссөн байна. Уураар томоохон хэрэглэгчдээс үзвэл 10586 Гкал буюу 23.3 %-ийг “Таван толгой түлш ХХК”-ны хэрэглээ, 7029 Гкал буюу 15.5%-ийг “Баялаг фийд” ХХК, эзэлж байна. Энэ онд “Агро трейд импекс”, “Цагаан ямаат кашимер”, “Мандах кейзинг”, “Женерал фүүдс”, “Лидер вүүл” гэсэн 5 хэрэглэгч шинээр нэмэгдсэн.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт, нүүрсний зарцуулалт

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2022 онд ЦЭХ-нд 596.8 гр/кВт.ц гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 2.3 гр/кВт.ц-аар буурсан, төлөвлөсөн хэмжээнээс 32.8 гр/кВт.ц-аар хэмнэж, дулаанд 197.57 кг/Гкал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 1.7 кг/Гкал-аар их,

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

төлөвлөгөөнөөс 3.0 кг/Гкал-аар буурч нийлбэр дүнгээр 1392.6 тн жишмэл түлш хэтэрсэн ба ГОТ-өөр 5696 тн жишмэл түлшийг хэмнэсэн байна.




График 8. Жишмэл түлшний хувийн зарцуулалт

Түлшний хувийн зарцуулалт хэмнэсэн шалтгаан нь:

- Конденсатын алдагдал 1.6%-иар буурсан
- Турбины даралт 0.7ата, температур 1.1 градусаар нэмэгдсэн
- Зуухны даралт 0.6ата, температур 1.2 градусаар нэмэгдсэн бөгөөд зуухны ажилласан цаг 95 цагаар буурсан.
- Тэжээлийн усны халуун 0.3 градусаар нэмэгдсэн.
- Үндсэн тоноглолын зогсолтын тоо зуухан дээр 9-өөр буурсан
- Нүүрсний дулаан гаргах чадвар төлөвлөсөн хэмжээнээс 84 ккал/кг-аар нэмэгдсэн.

Үндсэн тоноглолын зогсолт,

ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн шаардлагад зуухны зогсолтыг 52, турбины зогсолтыг 22 байхаар тогтоосон. Энэ жилийн гүйцэтгэлээр зуухны зогсолт-43, турбины зогсолт-23 байна.

Үндсэн тоноглолын зогсолтын 5 жилийн судалгааг графикаар үзүүлэв.




График 9. Үндсэн тоноглолын зогсолт